



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/40

Шивээговь сум

“Нөхөн сэргээлт - 2024” нэгдсэн арга
хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.2.2, 17.2.4, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/13 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын хэмжээнд “Нөхөн сэргээлт – 2024” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

Ч.Сугармаа

(Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга:

Б.Цолмон-Эрдэнэ

(Байгаль орчны асуудал хариуцсан
мэргэжилтэн)

Гишүүд:

О.Отгонбаяр

(Байгаль хамгаалагч)

Б.Шинэбаяр

(Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн
хошууч)

Э.Баярмагнай

(Газрын даамал)

Н.Амаржаргал

(1 дүгээр багийн Засаг дарга)

С.Отгонбаатар

(2 дугаар багийн Засаг дарга)

2. “Нөхөн сэргээлт – 2024” нэгдсэн арга хэмжээний 2021 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.


3. Ажлыг чанартай зохион байгуулж, хагас, бүтэн жилээр үр дүнг гарган тайлагнаж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн /Б.Цолмон-Эрдэнэ/-д, захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Ч.Сугармаа/-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын ... ОНЫ ...-р
сарын ... ний өдрийн ...
дугаар захирамжийн хавсралт



**“НӨХӨН СЭРГЭЭЛТ-2024” НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ШИВЭЭГОВЬ СУМАНД
ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2021.03.23

СЭВХҮҮЛ

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа /он/	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах албан хаагч	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
1.	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий ААН-р олборлолт явуулахад анхаарч ажиллах	03.01-12.01	Хууль бус түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтыг таслан зогсоосон байна.	Сумын байгаль орчны мэргэжилтэн байгаль хамгаалагч	МХГ БОАЖГ ЦХ
2.	Суманд байгаа туурь хог хаягдалтай талбай, суваг шуудууны мэдээг гаргаж, эзэн холбогдогчийг тогтоон зөрчлийг арилгуулна.	03.01-04.01	Эзэн холбогдогчийг тогтоон нөхөн сэргээлтийг хийлгэсэн байна.	Сумын байгаль орчны мэргэжилтэн байгаль хамгаалагч Газрын даамал	МХГ БОАЖГ ЦХ ГХБХБГ
3	Ажлын хэсгийн гишүүдийн уялдаа холбоог сайжруулах, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, харилцан мэдээлэл солилцож нөхөн сэргээлтийн тоон мэдээлэл, тайланг хагас, бүтэн жилээр гаргаж нэгдсэн ажлын хэсэгт хүргүүлэх	03.01-06.01 06.01.12.15	Арга хэмжээний тайланг БОАЖГ, ажлын хэсэгт хүргүүлсэн байна.	Сумын байгаль орчны мэргэжилтэн байгаль хамгаалагч	Ажлын хэсгийн гишүүд

4.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий ААН-р олборлолт явуулахад анхаарч ажиллах	03.01-12.01	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж хяналт тавьж ажиллана	Сумын байгаль орчны мэргэжилтэн байгаль хамгаалагч	ГХБХБГ Цагдаагийн хэлтэс
5	Барилга, авто-зам болон төмөр зам, бусад дэд бүтцийн бүтээн байгуулалтад ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмалын карьерын нөхөн сэргээлтийг тухай бүр хийлгүүлж, актаар хүлээн авах	03.01.12.01	Түгээмэл тархацтай ашигт малтмалын карьерын нөхөн сэргээлтийг хийлгүүлж, актаар хүлээн авсан байна.	Сумын байгаль орчны мэргэжилтэн байгаль хамгаалагч	БОАЖГ МХГ ЦХ
6.	Аж ахуйн нэгж, байгууллагын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд эвдэрсэн газруудад нөхөн сэргээлт хийлгэх ажлыг зохион байгуулах	03.01-12.01	Нөхөн сэргээлтийн ажлыг ААН, байгууллагын оролцоотой зохион байгуулсан байна.	Сумын байгаль орчны мэргэжилтэн байгаль хамгаалагч	Суманд үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ
7.	Шивээ-Овоо ХК-ийн олборлолтын үйл ажиллагаанаас үүдсэн эвдэрсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг стандартын дагуу чанартай хийлгүүлж акт үйлдэн хүлээн авах	03.01-12.25	Шивээ-Овоо ХК-ийн нөхөн сэргээлтийн ажлыг актаар хүлээн авсан байна. /Бга/	Сумын байгаль орчны мэргэжилтэн байгаль хамгаалагч	МХГ, ЦХ
8.	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолын хавсралтаар батлагдсан "Аймгийн хэмжээний барилгын туурь, хур хол, нүх шуудуу бүхий газрыг эзэнжүүлэх журам"-ын хүрээнд эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг иргэн аж ахуй нэгжтэй хамтран зохион байгуулах	2021-2024	Журмын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Сумын байгаль орчны мэргэжилтэн байгаль хамгаалагч	БОАЖГ
9	"Нөхөн сэргээлт 2024" нэгдсэн арга хэмжээний сумын ажлын хэсгийг байгуулан төлөвлөгөөг хэрэгжүүлнэ	03.01-03.15	Ажлын хэсэг байгуулагдсан байна.	Сумын байгаль орчны мэргэжилтэн байгаль хамгаалагч	